

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ**

2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
<b>Үүрэг, даалгавар АРВАН НЭГ:</b> Хог, хаягдлыг цагийн хуваарийн дагуу ачиж, тээвэрлэх зохицуулалтыг жигдрүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих.				
1	“Чингэлтэй Тохижилт үйлчилгээ” ХХК хог тээвэрлэлтийг шөнийн цагийн хуваарьт шилжүүлж, дүүргийн 1 дүгээр бүс болох төвийн 6 хорооны нийт 103 байршлын аж ахуйн нэгж, байгууллага болон орон сууцны хорооллын хог хаягдлыг оройны 20:00 цагаас өглөөний 05:00 цагийн хооронд тээвэрлэн нэмэлт хуваарийг мөрдөн ажиллаж байна. Мөн зуны улиралд ачаалал ихтэй зуслангийн ногоон бүсийн хог тээвэрлэлтийг “Найши трейд” ХХК 14 техник хэрэгслээр нэгдсэн хогийн цэгүүдийн хог тээвэрлэлтийг өдөр бүр 4-5 удаагийн давтамжтайгаар тээвэрлэж байна.			100
<b>Үүрэг, даалгавар АРВАН ХОЁР:</b> Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй барилгын хог хаясан болон бусад хог хаягдал үүсдэг байршлуудад хяналтын камер суурилуулах ажлыг зохион байгуулах.				
2	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын "Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам батлах тухай" 2023 оны 34 дүгээр тогтоол, "Хот тохижилт, цэвэрлэгээний талаар байгууллага, аж ахуйн нэгж иргэдээс дагаж мөрдөх тухай" 2012 оны 61, 2009 оны 63 дугаар тогтоолын дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэд хариуцан ажиллаж буй орчны 50м хүртэлх талбайн цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол зохион байгуулах, хог тээвэрлэлтийг тээвэрлэгч байгууллагуудын хуваарийн дагуу цагийн системээр гараас гарт өгч ачуулж хэвших, хамтран ажиллах, мөн тус дүүрэгт нийтийн эзэмшлийн гудамж, талбай, аж ахуйн нэгжүүдийн гадна талбайг хянах Камерын нэгдсэн төв байгуулагдсан бөгөөд тус камерын нэгдсэн системээр дамжуулан нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд ил задгай хог, хаягдал хаясан иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд арга хэмжээ авах талаар нийт аж ахуй нэгж, байгууллагуудад албан тоот, шаардлага хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн барилгын хог хаягдлыг тээвэрлэгч байгууллагууд тогтоосон тарифын дагуу төлбөр хураамжаа дүүргийн Татварын хэлтэст төлсний дараа хог тээвэрлэлтийг хийн ажиллаж байна.			100

<b>Үүрэг, даалгавар АРВАН ГУРАВ:</b> Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд зөвшөөрөлгүй гар дээрх худалдаа, үйлчилгээг цэгцлэх ажлыг зохион байгуулах.				
3	<p>Дүүргийн Засаг даргын дэргэдэх “Худалдаа үйлчилгээг зохицуулах Зөвлөл”-ийн хурлыг 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, хурлын тэмдэглэлийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Дүүргийн нутаг дэвсгэрт улирлын чанартай түр сүүдрэвчтэй худалдаа үйлчилгээ болон түргэн хоолны цэгийн байршил батлах тухай” А/130 дугаар захирамжаар нийт 52 цэгийн байршлыг баталсан.</p> <p>Дүүргийн Цагдаагийн газартай хамтран 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс хойш дүүргийн 10-19, 21-24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт давхардсан тоогоор 10 чиглэлд 20 алба хаагч 120 цагийн явган эргүүлийн үүрэг гүйцэтгэж нийтийн эзэмшлийн гудамж, талбайд зөвшөөрөлгүй гар дээрх худалдаа, үйлчилгээ эрхлэж байгаа иргэдэд шаардлага тавьж ажилласан. Үүрэг гүйцэтгэх хугацаанд гар дээрээс зөвшөөрөлгүй худалдаа эрхэлсэн 6 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 10.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 120,000 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.</p>			70
<b>Үүрэг, даалгавар АРВАН ДӨРӨВ:</b> 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ТҮК-иудыг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах.				
4	Тохижилт үйлчилгээний байгууллагуудын хог тээвэрлэлт болон зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний тендерийг 2024 оны 03 дугаар улиралд багтаан зарлахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна			30
<b>Үүрэг, даалгавар АРВАН НАЙМ:</b> Нийслэлийн хэмжээнд гэрэлтүүлгийн асалтад хяналт тавьж, асалт хангалтгүй байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын гэрээг цуцлах арга хэмжээ авч ажиллах.				
5	Үүрэг даалгаврын хүрээнд 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 21.20 цагаас 06 дугаар сарын 07-ны өдрийн 01.40 цагийн хороонд дүүргийн гэрэлтүүлгийн ашиглалт, үйлчилгээ хариуцдаг “Соёндрийм” ХХК, “Энержи комплекс” ХХК-ны гэрэлтүүлэгт үзлэг, шалгалтын ажлыг зохион байгуулсан бөгөөд уг үзлэг шалгалтаар “Соёндрийм ХХК”-ны хариуцдаг нийт 9707 гэрэлтүүлгийн 98 гэрэлтүүлэг унтарсан байсны 25-ыг нь засаж асалтын хувь 99.2, “Энержи комплекс” ХХК-ны хариуцдаг нийт 1925 гэрэлтүүлгийн 10 гэрэлтүүлэг унтарсан байсны 2-ыг нь засаж асалт 99.5 хувьтай байна.			100
<b>Үүрэг, даалгавар ГУЧИН ГУРАВ:</b> Дүүргийн Засаг даргын орлогч нар өөрсдийн нутаг дэвсгэрээр явж эвдэрч гэмтсэн явган зам, талбайг засаж сайжруулах ажлыг зохион байгуулах.				
6	Дүүргийн нутаг дэвсгэр дэх хорооллын дундах авто замын нүхэн эвдрэлүүдийг дүүргийн төсвийн хөрөнгөөр Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ-аас засварлахаар бэлтгэл ажлыг хангаж, 8 байршилд хөрөө тавих ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр эвдэрсэн замын судалгааг гаргасан. Тус төв нь одоогийн байдлаар Төв шуудангийн уулзвараас баруун 4 зам хүртэл Энхтайваны өргөн чөлөөний дагуу 400м2			70

	явган зам засварлаад байна. Мөн дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр “Чингэлтэй Тохижилт Үйлчилгээ” ХХК нь 4, 6, 10, 7, 20 дугаар хороодын 9 байршилд 650м2 явган замын ажлыг хийж гүйцэтгэсэн.			
<b>Үүрэг, даалгавар ГУЧИН ЗУРГАА:</b> Нийслэлийн хэмжээнд худалдан авах ажиллагааг эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. /Зураг төсөв, ажлын даалгаваргүй Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 35 дугаар хороо) Цэцэрлэгийн барилга, 240 ор (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо) гэх мэт/				
7	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/238 дугаар захирамжаар Чингэлтэй дүүрэгт эрх шилжин ирсэн “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (ЧД)” ажлын тоо хэмжээ, төсөв Захиалагчаас 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр ирсэн бөгөөд Дүүргийн Засаг даргын 2024 оны А/53 дугаар захирамжаар Үнэлгээний хороог байгуулсан. Тендер шалгаруулалтыг 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр зарлаж нээлтийг хийхэд 2 оролцогч санал ирүүлсэн боловч шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй тул бүх тендерээс татгалзаж шийдвэрлэсэн. 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр дахин зарласан, тендерийн материал хүлээн авч ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/547 дугаар захирамжаар эрх шилжин ирсэн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга ЧД” ажлын зураг төсөв, ажлын тоо хэмжээ ирээгүй байгаа тул тендер шалгаруулалтыг зохион байгуулаагүй байна.			70
<b>Үнэлгээний дундаж</b>				<b>77.1%</b>